



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 17/472

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын 1,9 дүгээр багийн авто замыг улсын чанартай авто замтай холбох автозамын барилга угсралтын ажил, Тарагт сумын Үржилийн булгийн төмөр бетон гүүр, далангийн хамт хийх ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах Комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ОРЛОГЧ




И.ДОРЖСҮРЭН

8223 11 0926

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар
сарын 10-ны өдрийн 74 дугаар
захирамжийн хавсралт



АВТО ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ц.Алтан-Эрдэнэ (Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч)

Ц.Нэргүй (Архивын тасгийн дарга, Архив, албан хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)

Холбогдох сумдын төлөөлөл

Гүйцэтгэгч аж ахуй нэгжийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Цогтбаатар (аймгийн Засаг даргын Тамгын газрын Авто Замын хяналтын улсын байцаагч)

-оОо-